

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Амгалан амаржих газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/172/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Утас: 327734 Аудитын менежер: Утас: 315558 Б энд С аудит ХХК-ийн Захирал Утас: 99050268	Х.Түвшинбаяр Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Я.Алтанцэцэг Цахим хаяг: altantsetseg.ya@audit.mn Д.Заяажаргал Цахим хаяг: info@bcauditllc.com
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-02-05 № 209
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Амгалан амаржих газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж, шалгагдагч байгууллагаас хараат бусаар ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй 526.4 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн байх зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Амгалан амаржих газар нь ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлж цалин урамшууллыг олгох зорилгоор үйл ажиллагаандаа KPI үнэлгээний системийг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Тус газар нь ээлжийн ажил хийдэг, нойргүйдэл, сэтгэл зүйн зөвлөгөө авах хүсэлтэй эмч, эмнэлгийн ажилтнуудыг сэтгэл зүйчийн зөвлөгөөнд хамруулан, эмчилгээ үйлчилгээний тасаг нэгжийн хамт олны дунд хэрэгцээнд үндэслэн хэсэгчилсэн уулзалт, ярилцлага, сургалт явуулсан байна

Аудитын гол асуудал

Амбулаторийн тасгийн үйл ажиллагааг өргөжүүлэх, тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж 2025 онд Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх кабинет, Дотрын дотоод шүүрлийн кабинет, ДОХ/ХДХВ/БЗХӨ-ийн кабинетыг тус тус шинээр байгуулан ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын 86 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэл 98.1 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<u>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</u>	16,873,027.93	24,000,532.02
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	16,873,027.93	24,000,532.02
<u>АВЛАГА</u>	-	1,218,625,441.54
Төлбөртэй үйлчилгээний авлага		1,218,625,441.54
<u>УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР</u>	-	-
<u>БАРАА МАТЕРИАЛ</u>	998,964,575.35	671,186,675.43
Түүхий эд материал	551,749,065.05	463,805,856.53
Тусгай зориулалттай материал		105,278,679.00
Эм боох материал	551,749,065.05	358,527,177.53
Хангамжийн материал	447,215,510.30	207,380,818.90
Бичиг хэрэг	20,374,490.00	14,722,250.00
Аж ахуйн материал	202,975,774.30	63,878,772.90
Сэлбэг хэрэгсэл	30,531,980.00	4,911,980.00
Барилгын засварын материал	8,608,976.00	18,423,376.00
Бусад хангамжийн материал	184,724,290.00	105,444,440.00
<u>НӨӨЦИЙН БАРАА</u>		
<u>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</u>		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,015,837,603.28	1,913,812,648.99
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
<u>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</u>	18,113,156,705.15	16,648,014,494.54
<u>Биет хөрөнгө</u>	17,897,794,725.15	16,434,820,314.54
Барилга, байгууламж	12,254,610,213.00	12,254,610,213.00
Хуримтлагдсан элэгдэл	(1,825,031,492.61)	(2,035,350,626.01)
Авто- тээврийн хэрэгсэл	340,307,521.00	340,307,521.00
Хуримтлагдсан элэгдэл	(90,180,854.08)	(122,920,854.04)
Машин, тоног төхөөрөмж	11,767,295,255.05	11,808,691,368.08
Хуримтлагдсан элэгдэл	(5,591,010,665.76)	(6,251,051,526.20)
Тавилга, аж ахуйн эд хогшил	456,790,182.50	475,003,422.50
Хуримтлагдсан элэгдэл	(278,048,183.69)	(311,244,082.96)
Бусад үндсэн хөрөнгө	681,395,290.00	694,610,068.00
Хуримтлагдсан элэгдэл	(366,111,924.26)	(417,835,188.83)
Дуусаагүй барилга, байгууламж	547,779,384.00	
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	215,361,980.00	213,194,180.00
Бусад	215,583,480.00	215,583,480.00
Хуримтлагдсан элэгдэл	(221,500.00)	(2,389,300.00)
<u>БУСАД ХӨРӨНГӨ</u>		
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	18,113,156,705.15	16,648,014,494.54
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	19,128,994,308.43	18,561,827,143.53
Богино хугацаат өр төлбөр		
Өглөг	2,681,490,848.10	2,848,458,602.03
Ажиллагчидтай холбогдсон өглөг	1,167,727,626.20	1,743,578,365.03

Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,024,162,045.13	1,084,352,681.00
Татаас, санхүүжилтийн өглөг	416,687,176.77	
Бусад өглөг	72,914,000.00	20,527,556.00
Байгууллагад төлөх өглөг	72,914,000.00	20,527,556.00
Урьдчилж орсон орлого	-	-
<u>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</u>	2,681,490,848.10	2,848,458,602.03
<u>УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН</u>	-	-
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	2,681,490,848.10	2,848,458,602.03
Засгийн газрын хувь оролцоо	16,447,503,460.33	15,713,368,541.50
Өмч: -Төрийн өмч	6,088,872,723.56	6,088,872,723.56
Дахин үнэлгээний нэмэгдэл	139,600.00	
Хуримтлагдсан үр дүн	10,358,491,136.77	9,624,495,817.94
Өмнөх үеийн үр дүн	11,082,558,620.08	10,358,630,736.77
Тайлант үеийн үр дүн	(724,067,483.31)	(734,134,918.83)
<u>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН</u>	16,447,503,460.33	15,713,368,541.50
<u>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</u>	19,128,994,308.43	18,561,827,143.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
<u>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</u>	13,515,556,223.00	16,917,793,544.00
Орон нутгийн төсвөөс	13,515,556,223.00	16,917,793,544.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,515,556,223.00	16,917,793,544.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	13,515,556,223.00	16,917,793,544.00
Бараа, үйлчилгээний орлого	2,744,230,006.77	1,765,250,231.18
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,013,247,861.54	1,101,543,497.83
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	487,885,226.00	344,712,268.00
Туслах үйл ажиллагааны орлого	525,362,635.54	756,831,229.83
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	1,594,219,872.00	596,147,301.40
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	136,762,273.23	67,559,431.95
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	16,259,786,229.77	18,683,043,775.18
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
<u>АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</u>	11,638,283,768.08	12,948,695,088.40
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	9,495,898,525.00	11,466,051,919.89
Цалин	3,805,048,637.16	5,241,029,561.55
Цалингийн тусгай нэмэгдлүүд	4,132,515,823.84	4,350,715,838.20
Унаа хоолны хөнгөлөлт	707,500,582.00	773,373,686.96
Урамшуулал	850,833,482.00	1,100,932,833.18
Нийгмийн хамгааллын шимтгэл	2,142,385,243.08	1,482,643,168.51
Тэтгэврийн даатгал	1,527,001,870.62	1,027,640,768.51

НИЙСЛЭЛИЙН АМГАЛАН АМАРЖИХ ГАЗРЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Тэтгэмжийн даатгал	134,799,355.37	113,750,600.00
ҮОМШӨ-ний даатгал	80,097,320.18	56,875,300.00
Эрүүл мэндийн даатгал	320,389,376.73	227,501,200.00
Ажилгүйдлын даатгал	80,097,320.18	56,875,300.00
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	5,207,481,027.08	5,845,090,233.44
Тогтмол зардал	347,224,819.45	408,811,732.09
Гэрэл цахилгааны зардал	162,915,700.37	214,914,906.14
Түлш, халаалтын зардал	52,462,764.15	49,402,115.87
Цэвэр, бохир усны зардал	131,846,354.93	144,494,710.08
Үйл ажиллагааны зардал	2,934,801,222.55	2,807,499,511.31
Хоол	519,928,400.00	529,053,100.00
Эм	2,414,095,342.55	2,278,446,411.31
Нормын хувцас зөөлөн эдлэл	777,480.00	
Бусад бараа үйлчилгээний зардал	1,925,454,985.08	2,628,778,990.04
Бичиг хэргийн материал	47,288,590.00	59,633,960.00
Тээвэр, шатахууны зардал	12,780,000.00	12,000,000.00
Шуудан холбооны зардал	38,686,520.67	41,656,906.63
Хог хаягдал, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	126,671,707.00	32,140,000.00
БҮТЭЗ	60,986,936.00	371,929,288.40
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	10,702,000.00	2,014,600.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	66,134,237.00	195,085,730.00
Даатгалын үйлчилгээ	232,200.00	384,900.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,741,612.00	17,151,000.00
Маягт хэвлүүлэх зардал	5,528,112.00	4,032,630.00
Урсгал засварын зардал	70,838,610.00	114,661,650.00
Тээврийн хэрэгслийн татвар	177,452.00	289,294.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо		600,000.00
Газрын төлбөр	1,759,956.00	1,759,956.00
Мэдээл, технологийн үйлчилгээ	20,538,500.00	20,900,000.00
Элэгдлийн зардал	1,448,998,552.41	1,754,539,075.01
Томилолтын зардал	3,390,000.00	
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	112,888,917.92	67,529,988.17
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	25,200,000.00	8,084,000.00
Урсгал шилжүүлэг	138,088,917.92	75,613,988.17
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	16,983,853,713.08	18,869,399,310.01
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(724,067,483.31)	(186,355,534.83)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)		-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
Хөрөнгө худалдсаны гарз		547,779,384.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)		547,779,384.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(724,067,483.31)	(734,134,918.83)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
Татаас, санхүүжилтийн орлого	6,350,431,986.80	15,282,480,925.69
Орон нутгийн төсвөөс	6,350,431,986.80	15,282,480,925.69
Нийгмийн даатгалын сангаас	11,434,179.00	
Эрүүл мэндийн даатгалын сангаас	6,338,997,807.80	15,282,480,925.69
Бараа, үйлчилгээний орлого	267,576,750.00	1,093,623,497.83
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхжүүих	209,841,000.00	344,712,268.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	57,735,750.00	748,911,229.83
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	6,618,008,736.80	16,376,104,423.52
Ажиллагчидтай холбогдсон зардал	4,478,016,913.00	12,372,844,349.57
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	4,068,409,513.00	10,927,566,949.57
Цалин	1,606,222,525.00	4,702,544,591.23
Цалингийн тусгай нэмэгдлүүд	1,777,585,950.00	4,350,715,838.20
Унаа хоолны хөнгөлөлт	368,596,853.00	773,373,686.96
Урамшуулал	316,004,185.00	1,100,932,833.18
Нийгмийн хамгааллын шимтгэл	409,607,400.00	1,445,277,400.00
Тэтгэврийн даатгал	298,172,200.00	990,275,000.00
Тэтгэмжийн даатгал	27,858,800.00	113,750,600.00
ҮОМШӨ-ний даатгал	13,929,400.00	56,875,300.00
Ажилгүйдлийн даатгал	13,929,400.00	56,875,300.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	55,717,600.00	227,501,200.00
Бараа, үйлчилгээний урсгал зардал	1,671,857,098.85	3,760,193,569.86
Тогтмол зардал	181,403,645.31	408,811,732.09
Гэрэл цахилгааны зардал	83,172,179.77	214,914,906.14
Түлш, халаалтын зардал	27,915,243.48	49,402,115.87
Цэвэр, бохир усны зардал	70,316,222.06	144,494,710.08
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	1,195,091,440.87	2,543,808,065.97
Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	924,333,040.87	2,022,674,965.97
Хоол, хүнс	270,758,400.00	521,133,100.00
Бусад бараа үйлчилгээний зардал	295,362,012.67	807,573,771.80
Бичиг хэргийн материал	15,175,490.00	24,179,020.00
Тээвэр, шатахууны зардал	6,000,000.00	12,000,000.00
Шуудан холбооны зардал	18,398,909.67	41,656,906.63
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	32,703,050.00	55,824,700.00
БҮТЭЭ	44,412,510.00	126,891,290.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	653,000.00	2,014,600.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	23,550,000.00	87,463,000.00
Маягт хэвлүүлэх зардал	13,089,512.00	26,710,630.00

Урсгал засварын зардал	79,277,910.00	166,842,610.00
Дотоод томилолтын зардал	3,390,000.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,305,300.00	143,482,877.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	24,000.00	17,060,000.00
Даатгалын үйлчилгээ	232,200.00	384,900.00
Тээврийн хэрэгслийн татвар	177,452.00	289,294.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо		600,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,538,500.00	24,800,000.00
Газрын төлбөр		1,759,956.00
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	11,434,179.00	
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		67,529,988.17
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал		8,084,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	6,149,874,011.85	16,133,037,919.43
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	468,134,724.95	243,066,504.09
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН(IV)	-	-
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	446,573,800.00	235,939,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН(V)	446,573,800.00	235,939,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V)	(446,573,800.00)	(235,939,000.00)
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)	21,560,924.95	7,127,504.09
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,150,099.37	16,873,027.93
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,873,027.93	24,000,532.02

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	6,088,872,723.56	139,600.00	11,082,558,620.08	17,171,570,943.64
Залруулсан үлдэгдэл	6,088,872,723.56	139,600.00	11,082,558,620.08	17,171,570,943.64
Тайлант үеийн үр дүн			(724,067,483.31)	(724,067,483.31)
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,088,872,723.56	139,600.00	10,358,491,136.77	16,447,503,460.33

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга			139,600.00	139,600.00
Залруулсан үлдэгдэл	6,088,872,723.56	139,600.00	10,358,630,736.77	16,447,643,060.33
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(139,600.00)		(139,600.00)
Тайлант үеийн үр дүн			(734,134,918.83)	(734,134,918.83)
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,088,872,723.56	-	9,624,495,817.94	15,713,368,541.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	15,579,212,300.00	15,282,480,925.69	296,731,374.31	98.1
Нийгмийн даатгалын сангаас	15,579,212,300.00	15,282,480,925.69	296,731,374.31	98.1
Бараа, үйлчилгээний орлого	393,380,000.00	684,811,765.74	(291,431,765.74)	174.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	354,956,000.00	344,712,268.00	10,243,732.00	97.1
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,551,000.00	340,099,497.74	(318,548,497.74)	1,578.1
Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	16,873,000.00		16,873,000.00	-
Нэмэлт санхүүжилтийн орлого	681,602,000.00	-	681,602,000.00	-
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан мөнгө	681,602,000.00		681,602,000.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ	16,654,194,300.00	15,967,292,691.43	686,901,608.57	95.9

МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)				
Ажиллагчидтай холбогдсон зардал	12,558,457,600.00	12,372,844,349.57	185,613,250.43	98.5
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	11,113,180,200.00	10,927,566,949.57	185,613,250.43	98.3
Цалин	5,178,235,200.00	4,702,544,591.23	475,690,608.77	90.8
Цалингийн тусгай нэмэгдлүүд	4,229,326,000.00	4,350,715,838.20	(121,389,838.20)	102.9
Унаа хоолны хөнгөлөлт	939,583,900.00	773,373,686.96	166,210,213.04	82.3
Урамшуулал	766,035,100.00	1,100,932,833.18	(334,897,733.18)	143.7
Нийгмийн хамгааллын шимтгэл	1,445,277,400.00	1,445,277,400.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	990,275,000.00	990,275,000.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	113,750,600.00	113,750,600.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	56,875,300.00	56,875,300.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	56,875,300.00	56,875,300.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгалын хураамж	227,501,200.00	227,501,200.00	-	100.0
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	3,920,006,800.00	3,511,706,849.60	408,299,950.40	89.6
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	2,857,204,800.00	2,543,808,065.97	313,396,734.03	187.65
Хоол	514,383,200.00	521,133,100.00	(6,749,900.00)	101.3
Эм	2,342,821,600.00	2,022,674,965.97	320,146,634.03	86.3
Бусад бараа үйлчилгээний зардал	1,062,802,000.00	967,898,783.63	94,903,216.37	91.1
Бичиг хэргийн материал	22,831,000.00	24,179,020.00	(1,348,020.00)	105.9
Тээвэр, шатахууны зардал	12,294,000.00	12,000,000.00	294,000.00	97.6
Шуудан холбооны зардал	37,413,000.00	41,656,906.63	(4,243,906.63)	111.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	63,310,900.00	55,824,700.00	7,486,200.00	88.2
БҮТЭЗ	129,018,500.00	126,891,290.00	2,127,210.00	98.4
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	2,293,200.00	2,014,600.00	278,600.00	87.9

НИЙСЛЭЛИЙН АМГАЛАН АМАРЖИХ ГАЗРЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	90,000,000.00	87,463,000.00	2,537,000.00	97.2
Маягт хэвлүүлэх зардал	27,129,500.00	26,710,630.00	418,870.00	98.5
Багаж, техник хэрэгсэл	208,414,200.00	202,567,100.00	5,847,100.00	97.2
Тавилга		22,216,900.00	(22,216,900.00)	
Урсгал засварын зардал	276,416,700.00	177,997,610.00	98,419,090.00	64.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	147,536,200.00	143,482,877.00	4,053,323.00	97.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	17,060,000.00	17,060,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	384,900.00	384,900.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	384,900.00	289,294.00	95,606.00	75.2
Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,515,000.00	600,000.00	915,000.00	39.6
Газрын төлбөр	2,000,000.00	1,759,956.00	240,044.00	88.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	24,800,000.00	24,800,000.00	-	100.0
Урсгал зардлын дүн	175,730,000.00	75,613,988.17	100,116,011.83	43.0
Бусад урсгал шилжүүлэг	175,730,000.00	75,613,988.17	100,116,011.83	43.0
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	167,646,000.00	67,529,988.17	100,116,011.83	40.3
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	8,084,000.00	8,084,000.00	-	100.0
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	16,654,194,400.00	15,960,165,187.34	694,029,212.66	95.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		16,873,027.93	(16,873,027.93)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		24,000,532.02	(24,000,532.02)	

ТОДРУУЛГА 5. АВЛАГА

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хорогдсон	Эцсийн үлдэгдэл
1	Төлбөртэй үйлчилгээний авлага		16,501,106,367.23	15,282,480,925.69	1,218,625,441.54
	Дүн		16,501,106,367.23	15,282,480,925.69	1,218,625,441.54

ТОДРУУЛГА 8. ӨГЛӨГ

№		Өмнөх он	Нэмэгдсэн	Хорогдсон	Тайлант он
1	Цалингийн өглөг		11,524,058,408.89	11,524,058,408.89	
2	НДШ,ЭМДШ-ийн өглөг	1,167,727,626.20	2,730,013,123.04	2,592,477,478.21	1,305,263,271.03
3	ХХОАТ		971,880,144.00	547,048,046.00	424,832,098.00
4	ҮЭ-ийн өглөг		111,533,073.00	98,050,077.00	13,482,996.00
5	Гэрэл, цахилгааны өглөг		214,914,906.14	214,914,906.14	-
6	Түлш халаалтын өглөг		49,402,115.87	49,402,115.87	-
7	Цэвэр, бохир усны өглөг		144,494,710.08	144,494,710.08	-
9	Эмийн өглөг	967,717,045.13	2,033,224,301.84	2,020,040,665.97	980,900,681.00
10	Хоолны өглөг		520,579,300.00	520,579,300.00	-
11	Бусад зардлын тооцоо	56,445,000.00	520,458,401.80	473,451,401.80	103,452,000.00
12	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	416,687,176.77		416,687,176.77	-
13	Бусад өглөг	72,914,000.00	516,783,026.00	569,169,470.00	20,527,556.00
14	Дүн	2,681,490,848.10	19,337,341,510.66	19,170,373,756.73	2,848,458,602.03

ТОДРУУЛГА 6. БАРАА МАТЕРИАЛ

№	ҮЗҮҮЛЭЛТ	Тусгай зориулалтын материал	Эм боох материал	Бичиг хэрэг	Аж ахуйн материал	Сэлбэг хэрэгсэл	Барилгын засварын материал	Бусад хангамжийн материал	Түлш, шатах тослох материал	Бараа материалын нийт дүн
1	Оны эхний үлдэгдэл		551,749,065.05	20,374,490.00	202,975,774.30	30,531,980.00	8,608,976.00	184,724,290.00		998,964,575.35
2	Нэмэгдсэн	105,278,679.00	2,112,939,731.79	53,975,020.00	163,617,096.00	6,239,000.00	42,537,910.00	15,424,950.00	12,000,000.00	2,512,012,386.79
3	Худалдан авсан		2,047,699,301.84	53,975,020.00	163,617,096.00	6,239,000.00	42,537,910.00		12,000,000.00	2,326,068,327.84
4	Хандиваар		52,134,481.95					15,424,950.00		67,559,431.95
5	Шилжүүлэн авсан	105,278,679.00	13,105,948.00							118,384,627.00
6	Бусад									-
7	Хасагдсан	-	2,306,161,619.31	59,627,260.00	302,714,097.40	31,859,000.00	32,723,510.00	94,704,800.00	12,000,000.00	2,839,790,286.71
8	Худалдсан, зарцуулсан		2,292,808,171.31	59,627,260.00	197,682,918.40	31,859,000.00	32,723,510.00	94,704,800.00	12,000,000.00	2,721,405,659.71
9	Шилжүүлсэн		13,353,448.00		105,031,179.00					118,384,627.00
10	Бусад									-
11	Эцсийн үлдэгдэл	105,278,679.00	358,527,177.53	14,722,250.00	63,878,772.90	4,911,980.00	18,423,376.00	105,444,440.00	-	671,186,675.43

ТОДРУУЛГА 7. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

№	Үзүүлэлт	Барилга	Авто тээврийн хэрэгсэл	Тоног төхөөрөмж	Бусад биет бус хөрөнгө	Тавилга эд хогшил	Дуусаагүй барилга	Бусад үндсэн хөрөнгө	Нийт дүн
1	ҮНДСЭН ХӨРӨНГӨ /ӨРТӨГ/								
1.1	Эхний үлдэгдэл	12,254,610,213.00	340,307,521.00	11,767,295,255.05	215,583,480.00	456,790,182.50	547,779,384.00	681,395,290.00	26,263,761,325.55
1.2	Нэмэгдсэн дүн	-	-	769,271,570.40	-	54,689,900.00	-	13,214,778.00	837,176,248.40
1.2.1	Худалдаж авсан			202,567,100.00		33,371,900.00			235,939,000.00
1.2.2	Үнэ төлбөргүй авсан			566,704,470.40		21,318,000.00		13,214,778.00	601,237,248.40
1.2.3	Дахин үнэлгээний нэмэгдэл								-
1.3	Хасагдсан дүн (-)	-	-	727,875,457.37	-	36,476,660.00	547,779,384.00	-	1,312,131,501.37
1.3.1	Худалдсан								-

1.3.2	Үнэгүй шилжүүлсэн						547,779,384.00		547,779,384.00
1.3.3	Акталсан			727,875,457.37			36,476,660.00		764,352,117.37
1.4	Үндсэн хөрөнгө дахин ангилсан								-
1.5	Үндсэн хөрөнгө, ХОЗҮХХ хооронд дахин ангилсан								-
1.6	Эцсийн үлдэгдэл	12,254,610,213.00	340,307,521.00	11,808,691,368.08	215,583,480.00	475,003,422.50		694,610,068.00	25,788,806,072.58
2	ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ								-
2.1	Эхний үлдэгдэл	1,825,031,492.61	90,180,854.08	5,591,010,665.76	221,500.00	278,048,183.69		366,111,924.26	8,150,604,620.40
2.2	Нэмэгдсэн дүн	210,319,133.40	32,739,999.96	1,387,916,317.81	2,167,800.00	69,672,559.27	-	51,723,264.57	1,754,539,075.01
2.2.1	Байгуулсан элэгдэл	210,319,133.40	32,739,999.96	1,387,916,317.81	2,167,800.00	69,672,559.27		51,723,264.57	1,754,539,075.01
2.2.2	Дахин үнэлгээгээр нэмэгдсэн								-
2.2.3	Үнэ цэнийн бууралтын буцаалт								-
2.3	Хасагдсан дүн	-	-	727,875,457.37	-	36,476,660.00	-	-	764,352,117.37
2.3.1	Данснаас хассан хөрөнгийн элэгдэл			727,875,457.37		36,476,660.00			764,352,117.37
2.3.2	Дахин үнэлгээгээр хасагдсан								-
2.3.3	Үнэ цэнийн бууралт								-
2.4	Эцсийн үлдэгдэл	2,035,350,626.01	122,920,854.04	6,251,051,526.20	2,389,300.00	311,244,082.96	-	417,835,188.83	9,140,791,578.04
3	ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН								-
3.1	Эхний үлдэгдэл	12,254,610,213.00	340,307,521.00	11,767,295,255.05	215,583,480.00	456,790,182.50	547,779,384.00	681,395,290.00	26,263,761,325.55
3.2	Эцсийн үлдэгдэл	10,219,259,586.99	217,386,666.96	5,557,639,841.88	213,194,180.00	163,759,339.54	-	276,774,879.17	16,648,014,494.54

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,920.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хоолны зардлыг 7,920.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	7,920.0	1	7,920.0			1	7,920.0				
Дүн	1	7,920.0	1	7,920.0			1	7,920.0				

Аудитаар нийт 526,411.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 26,685.2 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 456,716.3 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 43,009.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах Албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэр бүхий ажилчдад сар бүр илүү цагаар ажиллаагүй байхад анхан шатны баримтгүйгээр илүү цагийн хөлсийг тогтмол олгосон байна.	1	128,075.5			1	128,075.5						
Нөхцөлийн нэмэгдэл авахгүй ажилчдад нэмэгдэл олгосон.	1	6,507.5	1	6,507.5								
ХЧТА тэтгэмжийг ажилласан хоногийг давхардуулсан, цагийн бүртгэлээс илүү цагийг тооцож олгосон байна.	1	3,122.5	1	3,122.5								
Анхан шатны дэмжин нотлох баримтын бүрдэл	1	32,000.0			1	32,000.0						

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хангалтгүй, ямар ажил гүйцэтгэсэн нь тодорхойгүй, ажлын тайлан байхгүй зардлыг урсгал засварын зардалд бүртгэж тайлагнасан байна.											
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн.	1	43,009.9					1	43,009.9			
Тендер зарлахгүйгээр үнийг жижиглэн нийт 296,460.8 мянган төгрөгийн урсгал засвар болон харуул хамгаалалтын үйлчилгээ авсан, эмнэлгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, цэвэрлэгээний материал худалдан авсан, үүнээс 79,230.0 мянган төгрөгийн эмнэлгийн техник хэрэгслийг худалдан борлуулах тусгай зөвшөөрөлгүй газраас худалдан авалт хийсэн.	1	296,640.8				1	296,640.8				
Түрээслэгч байгууллагууд болох эмийн сан, кофе шопоос ашиглалтын зардлыг тооцож нэхэмжлээгүй, мөн харуул хамгаалалтын компани тус амаржих газрын автозогсоолыг ашиглан төлбөр авч байгаа боловч гэрээ байгуулаагүй, зогсоол ашигласны төлбөр төлдөггүй байна.	1	17,055.2	1	17,055.2							
Дүн	10	526,411.4	3	26,685.2	3	456,716.3	1	43,009.9			

Нийцлийн асуудлаар 655,653.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,650.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 654,003.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
2024, 2025 оны жилийн ажлын үр дүнгийн урамшууллыг улирал бүр олгосон боловч, 2025 оны нэгдүгээр сар, 12 дугаар саруудад 13 дах сарын цалин гэж ажилласан хугацаанд оногдуулж, хуульд заагдаагүй нэмэгдэл урамшуулал олгосон байна.	1	624,963.3			1	624,963.3		
Газрын дарга дээд шатны байгууллагын шийдвэргүйгээр өөртөө тушаал гарган урамшуулал олгосон байна.	1	1,650.0	1	1,650.0				
НЭМГ-ын даргын 2024 оны А/19 дүгээр тушаалаар орон тооны дээд хязгаарыг зөвлөх эмч нар орсоноор 300 гэж баталсан бөгөөд энэ орон тоог 7-оор хэтрүүлэн баталж, зөвлөх эмч болон хуулийн зөвлөх ажиллуулж цалинжуулсан байна.	1	29,040.0			1	29,040.0		
Дүн	4	655,653.3	1	1,650.0	2	654,003.3		